

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 134 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Төр, захиргааны 1 дүгээр байр, Бодь цамхагийн байруудын дунд 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр гарсан галын шалтгаан нөхцөл, хохирлын хэмжээг тогтоох, сэргээн засварлах, учирсан хохирлыг арилгах, байгууллагын ажиллах хэвийн нөхцөлийг бүрдүүлэх үүрэг бүхий шуурхай ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн
дарга

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
М.Отгонбаяр

Гишүүд:

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга Э.Ганхүү;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Өлзийбаяр;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн дарга А.Даваажаргал;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт
шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Х.Гантулга;

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн
штабын дарга, хурандаа Ж.Болдбаатар;

-Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга
Ч.Однасан;

-Улаанбаатар хотын Ерөнхий архитектор бөгөөд
Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний
газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ц.Тулга;

-Нийслэлийн Мэдээллийн технологийн газрын дарга О.Чинзориг;

-Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга Ж.Чүлтэмсүрэн;

-Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дарга Х.Эрдэнэбилэг;

-Нийслэлийн Цагдаагийн газрын дарга Д.Ядамдорж;

-Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Мөнхбат.

Нарийн бичгийн дарга

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболд

2. Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг /М.Отгонбаяр/-т даалгасугай.

3. Хохирлыг барагдуулахад шаардагдах хөрөнгийг Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т зөвшөөрсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

С.АМАРСАЙХАН